

**БАТЛАВ.**  
**СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ** **Н.НАМЖИЛСҮРЭН**  
\_\_\_\_\_оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ний/ны өдөр

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН УЛААНБАДРАХ СУМЫН  
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ**

2025.01.27

**УЛААНБАДРАХ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ДОТУУР БАЙРНЫ  
СУРАГЧДАД ХООЛ, ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ ТЕНДЕРИЙН БАРИМТ  
БИЧИГ**

Тендер шалгаруулалт/  
гэрээний нэр, дугаар:

***Дотуур байрны сурагчдын хоол, хүнсний бүтээгдэхүүн  
нийлүүлэх ДГАУБСЕБС/20250202005***

**2УЛААНБАДРАХ  
2025 ОН**

## НЭГ. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

**Улаанбадрах сумын Ерөнхий боловсролын сургууль** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Дотуур байрны хүүхдэд хоол, хүнсний бүтээгдэхүүн-ийг** нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Багцын дугаар	Багцын нэр
Багц 1	Мах, махан бүтээгдэхүүн
Багц 2	Бусад хүнс

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон бусад холбогдох материалыг хавсаргасан болно.

Тендер нь түүнийг нээснээс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Сонирхогч этгээд худалдан авах ажиллагааны цахим системээр тендерийн баримт бичигтэй үнэ төлбөргүй танилцах эрхтэй бөгөөд тендерийн баримт бичгийн үнийг төлснөөр тендер шалгаруулалтад оролцох эрхтэй болно.

Үнийн саналыг 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 11:00 цагаас өмнө Улаанбадрах сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын албан өрөөнд бичгээр ирүүлнэ.

Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээл тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх утсаар авч болно.

**Дорноговь аймгийн Улаанбадрах сум 4-р баг,  
Ерөнхий боловсролын сургуулийн захирал: 99027760  
Сургалтын менежер: 99059122**

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

Худалдан авах барааны талаарх дор дурдсан өгөгдлүүд нь тендерт оролцогчид өгөх зааварчилгаа/ТООЗ/-ны холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТООЗ-ны зүйл, заалттай зөрчилдвөл энэхүү хүснэгт дэх мэдээллийг зөв гэж үзнэ.

ТООЗ-ны холбогдох заалт	<b>А. Ерөнхий зүйл</b>
ТООЗ 1.1	Захиалагч нь: <b>Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Ерөнхий боловсролын сургууль</b>
ТООЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар: <b>ЕБС-ийн Дотуур байрны сурагчдын хоол, хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх ДГАУБСЕБС/20250202005</b>
ТООЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: <b>Улсын төсвийн урсгал зардал 50,728,700₮</b>
	<b>Б. Тендерийн баримт бичиг</b>
ТООЗ 8.1	Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг: <b>Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Н.Намжилсүрэн, гар утас: +976-99027760</b>
ТООЗ 8.1	Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах хугацааны хязгаар тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 5 хоногоос багагүй байна. <b>Тодруулгын хариуг цахим ХАА-ны систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>-д байршуулна. Тендерт оролцогч тодруулгыг цахимаар шалгах үүрэгтэй.</b>
	<b>В. Тендер бэлтгэх</b>
ТООЗ 11.1	Тендерт хэл нь <b>Монгол хэл</b> байна.
ТООЗ 12.1 (ё)	Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ.Үүнд: <ol style="list-style-type: none"> <li>1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар</li> <li>2. Татварын байгууллагын тодорхойлолт</li> <li>3. Харилцагч банкны тодорхойлолт /банк тус бүрээр/</li> <li>4. Сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан /2024 /</li> <li>5. Сүүлийн 1 жилийн туршлагын мэдээлэл/ ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн гэрээний хуулбар, гэрээний дугаар/</li> <li>6. Тендерт оролцох мэдэгдэл, үнийн санал</li> <li>7. Оролцогч компани танилцуулга</li> <li>8. Нийлүүлэх бараа бүтээгдэхүүнийг захиалагчийн техникийн тодорхойлолт тавигдах шаардлагын дагуу ханган нийлүүлэх тухай албан мэдэгдлийг эрх бүхий этгээдийн гарын үсэг зурж баталгаажуулах</li> <li>9. Захиалагчийн гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн албан мэдэгдэл.</li> </ol>

ТӨӨЗ 15.9 (б) (1) and (в) (3)	Бараа хүргэгдэх газар: <b>Дорноговь аймгийн Улаанбадрах сум</b>
ТӨӨЗ 15.9 (а) (3);(б)(3) болон (в)(5)	Бараа хүргэгдэх эцсийн цэг: <b>Дорноговь аймгийн Улаанбадрах сумын ЕБС-ийн хүнсний агуулах</b>
ТӨӨЗ 15.10	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад <b>тохируулахгүй тогтмол байна.</b>
ТӨӨЗ 16.1	Тендерийн валют: <b>Төгрөг байна.</b>
ТӨӨЗ 18.1 (а)	Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл: <b>Шаардлагагүй”</b>
ТӨӨЗ 18.1 (б)	Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: <b>1 жил</b>
ТӨӨЗ 18.1 (г)	Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: <b>Сүүлийн 1 жил</b>
ТӨӨЗ 18.1 (д)	Барааг нийлүүлсний дараах засвар, үйлчилгээ: <b>Шаардлагатай. Техникийн тодорхойлолтын дагуу шаардлага хангаагүй барааг буцаан шинээр солих шаардлагатай.</b>
ТӨӨЗ 18.2 (а)	Борлуулалтын хэмжээ: <b>Сүүлийн 1 жил /2024/ -ийн хугацаанд болруулалтын орлого багцуудын нийлбэр үнийн дүнгийн 40%-иас багагүй байх</b>
ТӨӨЗ 18.2 (б)	Гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо: <b>Шаардлагагүй</b>
ТӨӨЗ 18.2 (в)	Гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалт: <b>Шаардлагагүй</b>
ТӨӨЗ 18.2 (г)	Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: <b>Багцуудын нийлбэр үнийн дүнгийн 40%-иас багагүй байх</b>
ТӨӨЗ 18.2 (д)	Ашигтай ажилласан байх жилийн тоо: <b>1жил</b>
ТӨӨЗ 18.4	Дотоодын давуу эрхийн зөрүү: <b>Тооцохгүй.</b>
ТӨӨЗ 20.1	Тендер нээснээс хойш <b>45</b> хоногийн туршид хүчинтэй байна.
ТӨӨЗ 22.1	Тендерийн эх хувийн цахимаар ирүүлнэ.
	<b>Г. Тендер ирүүлэх</b>
ТӨӨЗ 23.3 (б)	Тендер хүлээн авах захиалагчийн хаяг: Тендер хүлээн авах этгээд: <b>Н.Намжилсүрэн</b> Байгууллагын хаяг: <b>Дорноговь аймгийн Улаанбадрах сумын ЕБС</b> Давхар болон өрөөний дугаар: <b>] Хичээлийн байр, 1 давхар, Захирлын өрөө</b> Аймаг, хот: <b>Дорноговь аймаг, Улаанбадрах сум</b> Улс: <b>Монгол Улс</b>

<p><b>ТӨӨЗ 23.3</b> (в)</p>	<p>Тендер оролцогч нь тендерийн иж бүрдэл <b>баримт бичгийг цахимаар бэлтгэн PDF өргөтгөлтэйгээр цахимаар ирүүлнэ.</b></p>
<p><b>ТӨӨЗ 24.1</b></p>	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: <b>2025 оны 02 дугаар сарын 03-ны өдөр</b> Цаг: <b>11 цаг 00 минут /Улаанбаатарын цагаар/</b></p>
	<p style="text-align: center;"><b>Д. Тендерийг нээх, үнэлэх</b></p>
<p><b>ТӨӨЗ 28.1</b></p>	<p>Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд: Байшин, гудамжны нэр: <b>Улаанбадрах сумын ЕБСургууль]</b> Давхар болон өрөөний дугаар: <b>Захирлын албан өрөө</b> Аймаг, хот: <b>Дорноговь аймгийн Улаанбадрах сум</b> Улс: <b>Монгол Улс</b> Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: Огноо: <b>2025 оны 02 дугаар сарын 03-ны өдөр</b> Цаг: <b>11 цаг 30 минут</b></p>
	<p style="text-align: center;"><b>Е. Гэрээ байгуулах эрх олгох</b></p>
<p><b>ТӨӨЗ 40.1</b></p>	<p>Захиалагч барааны тоо хэмжээг бууруулж болох хамгийн их хувь: 0 хувь Нийлүүлэх барааны тоо хэмжээг өсгөж болох хамгийн их хувь: 0 хувь</p>

## ГУРАВДУГААР БҮЛЭГ.

### ҮДИЙН ЦАЙ ХООЛОНД НИЙЛҮҮЛЭХ БАРАА БҮТЭЭГДЭХҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

#### I. Мах, махан бүтээгдэхүүн

1. Мах нь шинэ, чийгээ алдаагүй, технологийн дагуу цэвэрлэсэн, гадаргуу цэвэр зөв хадгалагдсан байна.
2. Гадны үнэр, амт байхгүй байна. /шивтэр, бензин гэх мэт, хэвлийн хөндийд/
3. Дайвар бүтээгдэхүүн болон махны ялгадасгүй байх / үхэр, хонины мах,, дайвар бүтээгдэхүүнд: бага малын 5-н цул байх /
4. Дайвар бүтээгдэхүүн бага малын дараах эрхтэн байх / элэг, бөөр, зүрх, уушиг/
5. Лабораторын шинжилгээний бичиг болон гарал үүслийн бичигтэй байна.
6. Шаардлагатай тохиолдолд захиалагч байгууллага шинжилгээнд давтан оруулсан тохиолдолд шинжилгээний төлбөрийн нийлүүлэгч тал хариуцах
7. Нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар хүргэж өгнө.
8. Дагалдах бичиг баримтад жолоочийн нэр, тээврийн хэрэгслийн дугаар, тоо хэмжээ,

үнэ зэргийг тусгасан байна.

#### II. Хүнсний ногоо:

1. Нийлүүлэгдэх ногоо нь монголд тариалагдсан байна.
2. Нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар хүргэж ирнэ.
3. Хорхойд идэгдээгүй байх
4. Илжирч ялзраагүй
5. Цохигдоогүй
6. Хайрагдаж, хөлдөөгүй
7. Төмс манжин луувангийн хар шороог арилгасан, байцааг давхаргын гадна талыг хуулж цэвэрлэсэн
8. Зориулалтын зооринд технологийн дагуу зөв хадгалсан
9. Лабораторын шинжилгээний бичигтэй байна.

#### Барааны нэр: Төмс

1. Төмсний диаметр 6-7 см-ээс 1 ширхэг төмсний дундаж жин нь 180-250 гр-аас багагүй байна.
2. Гэмтэж муудаагүй, зөөлрөөгүй, соёолоогүй, хайрагдаагүй, гадны үнэр амтгүй, элдэв механик хольцгүй байна. / гадаргуу нь шороо чулуу наалдаагүй чанарын шаардлага хангасан төмс байна/
3. Монгол үрийн төмсөөр тарьсан байх
4. 1 тн төмс бүрт 6 кг хорогдол тооцож түүнтэй хэмжээний төмс нэмж нийлүүлэх.

#### Барааны нэр: Байцаа

1. Байцаа нь нягтрал сайтай, муудаж гэмтээгүй гадны үнэр амтгүй, ялзраагүй байх
2. Байцааны дундаж жин 2-5.5 кг байна.
3. Гадаргууны илүүдэл навчийг цэвэрлэсэн байна.

#### Барааны нэр: Сонгино

1. Сонгино нь ялзарч муудаагүй, хатаж чийгээ алдаагүй, ааг амт сайтай, гадны үнэр амтгүй элдэв механик хольцгүй байна.
2. Монголын хөрсөнд тариалсан эрүүл бүтээгдэхүүн байна.
3. Соёолж хөгшрөөгүй байхаас гадна 1 ш сонгины дундаж жин 100-150 гр бай
4. 100 кг сонгино бүрт 2 кг хорогдол тооцож байх

#### Барааны нэр: Лууван

1. 1 ш луувангийн дундаж жин 200-300 гр байх ба механик элдэв хольцгүй, зөөлөрч муудаагүй чийгээ алдаагүй соёолоогүй гадны үнэр амтгүй байна.
2. Лууванд агуулагдах коратин болон бусад төрлийн амин дэм нь алдагдаагүй, багавтар чихэрлэг амттай улбар шар өнгөтэй байна.
3. 100 кг лууван бүрт 2 кг хорогдол тооцож түүнтэй тэнцэх хэмжээний лууван нэмж олгоно.

#### Барааны нэр: Манжин

1. Шар, хүрэн манжин нь стандартын шаардлага хангасан байна.
2. Гэмтээгүй, ялзарч муудаагүй хөгшрөөгүй, шинэ байна.

3. Гадаргууны шороо, үндэс, навчийг бүрэн цэвэрлэсэн стандартын шаардлага хангасан байна.

III. Бусад хүнсний материал

Барааны нэр: ГОЙМОНГИЙН ТӨРӨЛ / Мушгиа-Орос, Лабша-Монгол

1. Нийлүүлэгдэх гоймон нь үйлдвэрийн аргаар боловсруулагдсан олон улсын стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн байна.
2. 0.35-5 кг-аар савлагдсан, чийг аваагүй, хуурай, хөгцөрч муудаагүй, үйрч гэмтээгүй, хэлбэр дүрсээ алдаагүй, шинэ байна.
3. Өндөгний хольцтой, урсамтгай биш шинж чанартай байна.
4. 5-аас доошгүй төрөлтэй байна

Барааны нэр: БҮХ ТӨРЛИЙН БУДАА

1. MNS 0142:1985 техникийн шаардлага хангасан байна.
2. Гадны механик хольцгүй ба үнэр амтгүй, бяцарч хуваагдаагүй байна.
3. Цагаан будаа том ширхэгтэй, агшаахад нялцайхгүй байх.

Барааны нэр: ГУРИЛ / Монгол/

1. MNS 0244:2009 техникийн шаардлага хангасан байна.
2. Гадны механик хольцгүй ба үнэр амтгүй, хөгцөрч муудаагүй байна.
3. 1-р зэргийн тэмдэгтэй байна. /дээд ба 1-р гурил/
4. 25-50 кг-аар савлагдсан байна.
5. Чийгээ алдаагүй шинэ байна.

Барааны нэр: ДАВС /Монгол /

1. 0.5-1 кг-аар савлагдсан, чийг аваагүй хуурай бөөгнөрч хатуураагүй байна.
2. Иодын агууламж зохих түвшинд байна

Барааны нэр: УРГАМЛЫН ТОС /Орос/

1. Зориулалтын хуванцар сав баглаанд савласан байна.
2. Эрүүл ахуйн шаардлага хангасан байна. Элдэв үнэр амтгүй өнгөгүй байна.

Барааны нэр: БУСАД ХҮНС

- Исгэгч
- Цагаан будаа
- Гурвалжин будаа
- Шар будаа
- Исгэгч Масло
- Далайн байцай
- Элсэн чихэр
- Хоол амтлагч \перц, супер амтлагч, вигор...гм\
- Хуурай цай / нүдэж буталдаг том/
- Шингэн сүү /1кг-аас багагүй байх/
- Каш /Орос улсын стандарттай дүйцэхүйц байх/
- Зориулалтын саванд савласан байна. \сав нь гэмтэж хагараагүй байх\
- Дагалдах бичиг баримтад тоо хэмжээ, үнэ зэргийг тусгасан байна
- Хадгалалтын хугацаа дуусаагүй бүтээгдэхүүн байна.
- Лабораторын хугацаа дуусаагүй бүтээгдэхүүн байна.
- Лабораторын шинжилгээний бичигтэй байна.

**ДӨРӨВ. ДОТУУР БАЙРНЫ СУРАГЧДЫН ХООЛ,  
ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХИАЛГЫН ХЭМЖЭЭ**

№	Материалын нэр	Сар										Нийт дүн	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
		1	2	3	4	5	6	9	10	11	12			
<b>Багц 1</b>	Мах /кг/	50	120	120	100	100	70	121	120	120	100	<b>1021</b>	<b>12,000</b>	<b>12,252,000</b>
<b>Багц 2</b>	Төмс /кг/	25	100	70	80	80	60	100	100	100	80	<b>795</b>	<b>2,500</b>	<b>1,987,500</b>
	Хүнсний ногоо /кг/	80	310	280	200	250	150	310	310	310	200	<b>2400</b>	<b>4,500</b>	<b>10,800,000</b>
	Жимс, жимсгэнэ /кг/	15	40	25	30	40	60	25	60	40	20	<b>335</b>	<b>9,500</b>	<b>3,182,500</b>
	Сүү, сүүн бүтээгдэхүүн /л/	50	90	90	70	70	20	110	110	100	70	<b>780</b>	<b>6,000</b>	<b>4,680,000</b>
	Гурил /кг/	20	120	120	80	70	75	105	105	105	75	<b>875</b>	<b>4,000</b>	<b>3,500,000</b>
	Гурилан бүтээгдэхүүн /кг/	30	87	85	75	70	60	90	90	90	70	<b>747</b>	<b>6,000</b>	<b>4,482,000</b>
	Төрөл бүрийн будаа /кг/	25	110	120	90	90	50	112	112	112	90	<b>911</b>	<b>4,500</b>	<b>4,099,500</b>
	Ургамлын тос /л/	5	18	18	15	10	10	22	20	20	13	<b>151</b>	<b>13,000</b>	<b>1,963,000</b>
	Сахар, чихрийн зүйл /кг/	5	18	15	10	10	10	20	20	20	15	<b>143</b>	<b>5,000</b>	<b>715,000</b>
	Цагаан идээ/кг/	10	30	30	20	20	15	80	70	50	30	<b>355</b>	<b>8,500</b>	<b>3,017,500</b>
<b>Мөнгөн дүн</b>														<b>50,679,000</b>

## Тендер илгээх маягт

[огноо]

**[Захиалагч байгууллагын нэр]-д**

Манай **[тендерт оролцогчийн нэр]** нь танай байгууллагаас зарласан **[тендер шалгаруулалтын нэр, дугаар]** тендер шалгаруулалтад **[үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр]** төгрөгөөр тендерийн баримт бичигт заасан хуваарийн дагуу бараа нийлүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендерийн баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээний маягт)-ын нөхцөлтэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Тендерт оролцогч, түүний түншлэлийн гишүүнтэй холбоотойгоор тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 15.1-д заасан нөхцөл байдал үүсээгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт **[“санал болгоно” эсхүл “санал болгохгүй” гэж бичих]**. **[Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих]**.
5. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш **[30 ба түүнээс дээш хоногийн тоо]** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
6. Тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 6 дугаар зүйл, 12.4 болон 15.1-д заасныг зөрчсөн, эсхүл тендерт хуурамч баримт бичиг, мэдээллийг хүргүүлсэн бол уг тендерийг илт худал мэдээлэл бүхий тендер гэж тооцохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Тендерт санал болгосон бараа нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.
8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

**[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,**

**эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,**

**албан тушаал, гарын үсэг,**

**байгууллагын тамга, тэмдэг]:**

**Хаяг:**

## ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

[Тендер шалгаруулалтын нэр] гэрээ  
Дугаар № [Тендер шалгаруулалтын дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [нийлүүлэгчийн нэр] (цаашид “нийлүүлэгч” гэх) нь Нийлүүлэгчээс ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Нийлүүлэгчийн хооронд бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу нийлүүлэх Барааны үнэ нь **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр бичих]** төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг нийлүүлэгч .....-ийн харилцах .....банкны ..... дугаар дансанд шилжүүлнэ.
3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
  1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
  2. Гэрээ баталгаажуулах маягт;
  3. Гэрээний тусгай нөхцөл;
  4. Гэрээний ерөнхий нөхцөл;
  5. Техникийн тодорхойлолт;
  6. Бараа нийлүүлэлтийн хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
  - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл  
Эцэг/эх/ -ийн нэр:  
Нэр:  
Албан тушаал:  
Ажлын утас:  
Гар утас:  
Цахим шуудан:
  - 4.2. Нийлүүлэгчийн төлөөлөгчийн мэдээлэл  
Эцэг/эх/-ийн нэр:  
Нэр:  
Албан тушаал:  
Ажлын утас:  
Гар утас:  
Цахим шуудан:

### ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

### НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА